



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 19 өдөр

Дугаар А/523

Хэрлэн сум

“Ахуйн үйлчилгээ-2023” нэгдсэн
арга хэмжээг зохион байгуулах ажлын
хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Засгийн газрын 2019 оны “Үндэсний хөтөлбөр” батлуулах тухай 418 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ахуйн үйлчилгээний салбарт дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, стандартад нийцсэн үйлчилгээг иргэдэд хүргэх, албан бус хөдөлмөр эрхлэлтийг багасгаж ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор “Ахуй үйлчилгээ-2023” арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.


Ажлын хэсгийн ахлагч:	Ж.Энх-Амгалан	Хүнс, Хөдөө аж ахуйн газрын дарга
Нарийн бичгийн дарга:	Г.Оюун-Эрдэнэ	Хүнс, Хөдөө аж ахуйн газрын Үйлдвэр худалдаа үйлчилгээний албаны дарга
Гишүүд:	Г.Ариунчимэг	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн бодлого хариуцсан мэргэжилтэн
	Л.Наранбат	Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын дарга
	Ж.Ганчимэг	Хүнс, Хөдөө аж ахуйн газрын хөнгөн болон жижиг дунд үйлдвэрлэл, хоршоо, ахуй үйлчилгээний асуудал хариуцсан мэргэжилтэн
	Б.Болд-Эрдэнэ	Политехникийн коллежийн захирал
	Г.Нэргүйбаатар	Биеийн тамир, спортын газрын дарга
	Д.Батболд	Худалдаа аж үйлдвэрийн танхимындарга

2.

- Я.Хишигням Үйлдвэрлэл, үйлчилгээний
хоршоодын холбооны Тэргүүн
- Т.Бямбатогоо Аймгийн үсчин гоо засалчдын
холбооны дарга
- Ц.Амгаланбаатар Аймгийн үйлдвэр, үйлчилгээний
хоршоодын холбооны дарга

2.Дээрх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан батлуулж өндөр түвшинд үр дүнтэй зохион байгуулж тайлагнаж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Ж.Энх-Амгалан)-т, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Э. Мөнх-Эрдэнэ)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ